




ХИЧЭЭЛ 10

УНШИХ ЗҮЙЛ: ҮЙЛС 8:26-40; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 107-109.

Бурханы Үт

Өмнө нь та нарт хэн нэг хүний уншиж өгсөн зүйлийг та нар ойлгохгүй байх тохиолдол гарч байсан уу? Олон жилийн өмнө нэгэн чухал хүн Бурханы үгийг уншиж байсан ч түүнийгээ ойлгохгүй байжээ. Түүнд хэн тусалж чадах байсан бэ?



илип Шомрон хотод Есүсийн тухай сургаал заадаг байлаа. Түүнийг Иерусалимд эргэж ирсэн хойно нь Бурхан түүн

рүү нэг элчээ илгээж, "Иерусалимаас Газа орох цөлийн замаар яв" гэж хэлүүлсэн байна.



Филип ямар учраас тийш явах шаардлагатайгаа ойлгоогүй ч тэрээр замаар алхаж явав. Түүнийг замаар алхаж явтал алсад тоос босох нь үзэгджээ. Нэгэн морин тэрэгтэй хүн дөхөж явлаа.

Тэрээр цэргүүд бас зарц байхыг харав. Харуулууд Етиопын хатан хаанд зүтгэдэг нэгэн захирагч ажилтай хүнийг хамгаалж явсан юм. Түүнийг Исаиа 53-р бүлгээс ямар нэг зүйл уншин байхыг Филип сонслоо.

Филип инээмсэглэв. Бурхан түүнийг энэ хүн рүү илгээсэн болохыг тэрээр сая л ойлголоо. Бурхан Филипийг энэ хүнтэй уулзуулахыг хүссэн байна. Түүнийг үгийг уншиж

Цээжлэх Ишлэл:

"Өөрийн үгийн дагуу
надад ухаарлыг
хайрлаач"
дуулал 119:169.

Тол Санаа:

Үгийг нь ойлгоход
Бурхан бидэнд
тусалдаг.

ойлгоход нь Филип энэ хүнд туслах учиртай ажээ. Филип нөгөө тансаг тэрэг рүү дөхөж очоод, "Эрхэм ээ, та уншиж байгаа зүйлээ ойлгож байна уу?" гэж асуулаа.

Захирагч дээш харан "Би яаж ойлгох билээ дээ. Хэн нэг хүнээр тайлбарлуулахгүй бол юу ч ойлгохгүй нь. Та үүнийг ойлгодог уу?" гэж асуусан юм.

Филип толгой дохиж "Тийм ээ, би ойлгодог" хэмээн хариулав.

Ингээд захирагч Филипийг тэргэндээ урьж суулгаад, "Надад хэлээч, энэ үгс юу гэсэн утгатай юм бэ?"


Тэргээр аялж явахдаа Филип Етиопын албаны хүнд Есүсийн тухай сайн мэдээг тайлбарлаж өгсөн юм. Бурханы хүү Есүс энэ дэлхий дээр хүүхэд болж ирсэн бөгөөд өсөж том болоод хүн бүрийн гэмийн төлөө амиа өгсөн ч үхлээс амилсан гэдгийг ярьж өгчээ. Филип мөн түүнд Есүс удахгүй дахин ирж өөрт нь итгэсэн хүмүүсийн хамт үүрд мөнх амьдрахаар Мөнхийн улс руугаа авч явах болно гэдгийг ярьсан байна.

Бурханы Ариун сүнс түүний зүрх сэтгэлд үгээ хэлэхэд албаны хүн энэ сайн мэдээнд итгэсэн юм. Захирагч эргэн тойрноо тойруулан харав. Тэрээр тэргээ зогсоолоо. "Энд ус байна" гэж хашгираад "Би яагаад яг одоо усан баталгаа хийлгэж болохгүй гэж" хэлэв.

Ингээд Филип албаны хүн хоёр ус руу явж орлоо. Замын хажууханд албаны хүн усан баталгаа хүртжээ.

Хоёр хүнийг уснаас гарч ирэнгүүт Филип алга болов. Бурханы Ариун сүнс түүнийг Их Эзэний тухай яриулахаар өөр хот руу авч оджээ.

Етиоп албаны хүн тэргэндээ иргэж ирээд аян замаа үргэлжлүүлсэн байна. Есүс өөрт итгэсэн хүн бүрийг аврахын тулд алагдсан гэдэг мэдээг найз нөхөдтэйгөө хурдхан хуваалцах юмсан гэдэг хүсэлдээ тэр тэсэж ядан явж байлаа. Библийг ойлгоход хэн бидэнд тусалж чадах вэ?



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногт өдөр бүр түүхээ уншаад цээжлэх ишлэлээ хөдөлгөөний хамт хийгээрэй.

Өөрийн үгийн дагуу ...Алгаа нийлүүлээд дэлгэх.
нададӨөрийгөө заах.
ухаарлыг хайрлаач...Дух руугаа заах.
Дуулал 119:169Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн Библиэ хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Филип хэрхэн Етиоп Библийг уншиж ойлгоход нь тусалсан тухай ярихад нь хүүгээ урамшуулаарай. Эсвэл нэг цаасыг голоор нь нугалж байгаад нүүрэн талд нь Библи гэж бичээрэй. Дараа нь түүнийг дэлгээд дээр нь хүүхдээрээ ямар нэг Библийн түүх зуруулаарай.

ДАВАА

Гэрт чинь хэдэн Библи байгааг тоолж, заалгаарай. Мэддэг ишлэлийг нь янз бүрийн Библийн орчуулгатай харьцуулаарай. Хүүхдээ толинд харуулаад, өөрсдийг нь тодорхойлуулаарай. Хэлэх: Бурханы өршөөл энэрэл бол Библид бичигдсэн зүйлийг яг толинд харж байгаа юм шиг ойлгоход тусалдаг.

МЯТМАР

Хүүхдээрээ гар чийдэн бариулуулаад хүүхдээрээ гэр дотроо замчлуулж алхаарай. Бурханы үг болсон Библи бидний амьдралын гэрэл

мөн гэдгийг хүүхдэдээ тайлбарлаарай. Библийн тухай дуу дуулаад, дараа нь Бурханд талархаарай.

ЛХАТВА



Цаасан дээр лимоны шүүсээр цээжилсэн ишлэлээ бичээрэй. Хүүхдээрээ чийдэн бариулаад бичигний ар талаас тусгуулж бичиг ямар харагдаж байгааг ажиглаарай. Хэлэх: Хүнд хэцүү зүйлийг ойлгоход маань Бурхан тусалдаг. Бид Бурханыг харж чаддаггүй ч Тэр хамт байгааг бид мэддэг.

ЛҮРЭВ

Үйлс 8:26-40-г хамтдаа уншаарай. Асуух: Филип захирагчид хэрхэн тусалсан бэ? Яагаад Филип, албаны хүн хоёр ус руу орсон бэ? Хүүхдээрээ угаалгын өрөөнд ямар нэг хүүхэлдэйд усан баталгааг хийлгүүлнэ үү. Тэр ч бас нэгэн өдөр усан баталгаа хүртэх болно гэдгийг түүнд бас сануулаарай.

БААСАН

Гэрийнхэндээ бүгдэнд нь зориулан хүүхдээрээ хүнс бэлдүүлээрэй. Жишээ нь тэрэгний хэлбэртэй талх зүсүүлэх. Дээр нь дугуй нэм. Лууван эсвэл амуугаар морийг нь хий. Хоолыг идэх зуураа Библийн түүхийг дахин ярьж өгөөрэй.

Хүүхдээсээ хүнд асуулт асуу гэж хэлээрэй. Дараа нь түүнийгээ энгийн үгээр тайлбарла. Хэлэх: Есүс ч бас ийм зүйлийг чамд хийж өгөх болно.

Ойлгох чадварыг өгсөнд нь Бурханд талархаарай.

